



I-III/2021

Тархаасан: 2021 оны 4 дүгээр сарын 13




Үнэмлэхүй бага температур 2021 оны 3 дугаар сард Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ суманд – 37.1 °С-д хүрсэн байна

Цаг агаар

Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 3 дугаар сард Өмнөговь аймгийн Манлай суманд +22.9°C, үнэмлэхүй бага температур Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ суманд -37.1°C-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (°C), ОЛОН ЖИЛИЙН ДУНДАЖТАЙ¹ ХАРЬЦУУЛСНААР, станцын байршлаар, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



¹ - 1981-2010 он

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2021 оны 3 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр Дархан-Уул аймгийн Дархан суманд 16.0 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутгаар түр зуур 40 м/с-д хүрсэн байна.


Агаарын чанар

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын дундаж агууламж 2021 оны 3 дугаар сард бүх станцуудад 0.019 мг/м³– 0.141 мг/м³-д хүрсэн бөгөөд 13-р хороолол, Нисэх, Баруун дөрвөн зам, Баянхошуу, 32-ын тойрог, 248-р цэцэрлэг, Хайлааст, Зурагт, 1-р хороолол орчимд агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.004 мг/м³– 0.091 мг/м³-ээр давсан байна.


Харин азотын давхар ислийн сарын дундаж агууламж 2021 оны 3 дугаар сард бүх станцуудад 0.006 мг/м³– 0.057 мг/м³-д хүрсэн бөгөөд Баруун дөрвөн зам орчимд 0.057 мг/м³-д хүрч агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.007 мг/м³-ээр давсан байна.

PM 10 тоосонцрын сарын дундаж агууламж 2021 оны 3 дугаар сард бүх станцуудад 0.047 мг/м³ – 0.195 мг/м³-д хүрсэн бөгөөд Амгалан, Баруун дөрвөн зам, 32-ын тойрог, 13-р хороолол, 1-р хороолол, Ургах наран хороолол, Баянхошуу, Хархорин зах орчимд 0.105 мг/м³ – 0.195 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.005 мг/м³ – 0.095 мг/м³-ээр давсан байна.


ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ ХҮХЭРЛЭГ ХИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, мг/м³



ЗУРАГ 3. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ PM 2.5 ТООСОНЦРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, станцаар, мг/м³




ЗУРАГ 4. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ PM 10 ТООСОНЦРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, станцаар, мг/м³



Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисуудын дундаж агууламжийг авч үзвэл, 2021 оны 3 дугаар сард азотын давхар исэл өмнөх оны мөн үеэс 0.009 мг/м³ (20.5%)-ээр, өмнөх сараас 0.006 мг/м³ (15.4%)-ээр, PM 2.5 тоосонцрын агууламж өмнөх оны мөн үеэс 0.001 мг/м³ (3.2%)-ээр, өмнөх сараас 0.029 мг/м³ (46.4%)-ээр тус тус бага байсан бол хүхэрлэг хий өмнөх оны мөн үеэс 0.032 мг/м³ (79.3%)-ээр их байсан бол өмнөх сараас 0.067 мг/м³ (48.4%)-ээр бага байсан байна. PM 10 тоосонцрын агууламж өмнөх оны мөн үеэс 0.027 мг/м³ (35.3%)-ээр, өмнөх сараас 0.003 мг/м³ (3.4%)-ээр тус тус өндөр байна.

ЗУРАГ 5. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, мг/м³



ХҮСНЭГТ 1. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАХ БОДИСЫН АГУУЛАМЖ АГААРЫН ЧАНАРЫН СТАНДАРТ ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ТОХИОЛДЛЫН ТОО, станцаар, 2021 оны 3 дугаар сард

Станцын байршил	Хүхэрлэг хий (SO ₂)	Азотын давхар исэл (NO ₂)	Нүүрс төрөгчийн дутуу исэл (CO)	Тоос (PM ₁₀)	Тоос (PM _{2.5})
Мишээл экспо	7	3	-	12	-
Баруун 4 зам	22	25	-	17	10
1-р хороолол	28	15	-	19	10
13-р хороолол	15	15	-	18	3
32-ын тойрог	26	3	-	15	-
Хархорин	11	14	-	18	-
Ургах наран хороолол	1	5	-	13	-
Хайлааст	28	-	-	1	13
248-р цэцэрлэг	26	2	-	-	-
Богд хааны ордон музей	-	-	-	2	-
Нисэх	14	-	-	4	1
Толгойт	-	-	-	-	2
Зурагт	25	-	2	9	13
Амгалан	7	1	-	13	4
Баянхошуу	20	-	-	21	-

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2021 оны 1 дүгээр улиралд 1137 болж, өмнөх оны мөн үеэс 152 (15.4%)-аар өссөн байна. Объектын түймэр 753 удаа гарч, өмнөх оны мөн үеэс 19 (2.5%)-өөр буурсан байна.

Улсын хэмжээнд 2021 оны 1 дүгээр улиралд сард боом өвчний 1, мал, амьтны халдварт галзуу өвчний 6, шинэ төрлийн Корона вируст (Covid-19) халдварын 7232 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 2. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I – III	2019 I – III	2020 I – III	2021 I – III	<u>2021 I – III</u> % 2020 I – III
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	тоо	1 219	1 315	985	1 137	115.4
Амь насаа алдсан хүн	тоо	32	29	41	69	168.3
Түлэгдсэн, бэртсэн, өвчилсөн хүн	тоо	28	6	35	7 251	207.2 ¹
Шатсан гэр, орон сууц	тоо	451	555	456	191	41.9
Объектын түймэр	тоо	958	1200	772	753	97.5
Учирсан хохирол	тэрбум төгрөг	10.2	3.5	4.2	7.0	166.7
Зарцуулсан зардал	сая төгрөг	340.2	508.3	50.7	377.6	7.4

¹ - Дахин их

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны 1 дүгээр улиралд нийт 69 хүн амь насаа алдаж, 7251 хүн түлэгдэж, бэртэж, өвчилж, хордсон байна.

Амь насаа алдсан шалтгааныг нь авч үзэхэд бичил уурхай, нурангийн улмаас 1 хүн, шинэ төрлийн Корона вируст халдварын улмаас 8 хүн, хүчтэй салхи, шуурганы улмаас 10 хүн, объектын түймрийн улмаас 24 хүн, бусад золгүй явдлын улмаас 26 хүн амь насаа алджээ.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны 1 дүгээр улиралд 191 гэр, байшин, орон сууц шатаж, өмнөх оны мөн үеэс 265 (58.1%)-ээр буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны 1 дүгээр улиралд 7.0 тэрбум төгрөгийн хохирол учирч, 377.6 сая төгрөг зарцуулсан байна.

Аюулт үзэгдэл, ослоос 2021 оны 1 дүгээр улиралд 1020 хүнийг аварч, 27.5 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг хамгаалсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.

Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газар

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 5 дугаар сарын 15



Эдийн засгийн статистикийн
газрын дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн
газрын статистикч Д.Баасан
Утас : (976-51)-261502